

ДЭЛГЭРЦОГТ: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ АВЧ

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023-06-08

Амардалай

№	Өгсөн үүрэг даалгавар	Үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
1	Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг аймгийн сайтад 05 сарын 01-ний дотор багтаан бүрэн байршуулах	Мэдээлэл оруулсан байх	Шалгуур үзүүлэлтийг хангах	90,0	90,5	Шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг Дундговь сайтад бүрэн байршуулав. 98 шалгуурын дундаж хувь 44.67 байна	45
2	Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдалд улирал бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангах	Мэдээлэл оруулсан байх	Шалгуур үзүүлэлтийг хангах	90	100	2023 оны эхний 5 сарын байдлаар ТЕЗ болон 6 төсөвт байгууллага бүтэн жилээр оруулах 21, улирал бүр оруулах 6, сар бүр оруулах 72, Тухай бүр оруулах 48 нийт 126 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл хугацаа хоцроосон. нийт 123 мэдээг цаг хугацаанд оруулж мэдээний хэрэгжилт 97,6 хувь байна. Сумын ТЕЗ болон төсөв байгууллагуудын төсвийн ил тод байдлын мэдээг шилэн данс болон Дундговь сайтаар тухай бүр мэдээлж байгаа.	97,6
3	Тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх мэдээллийг Сангийн яамнаас баталсан загвар	Жилийн төлөвлөгөө батлуулсан байх	үр дүнг тооцох	68	70	2023 оны сумын ОНХС-ийн төсөл хөтөлбөр арга хэмжээг Сумын ИТХ-ын 2022 оны 12 сарын 19 ний өдрийн тогтоолоор шилжих 1, шинээр эхлэх 2, Малын тоо толгойн албан татвараар	45

	маягт Хавсралт 1-ийн дагуу гаргаж, сумын ИТХ-аар батлуулан хэрэгжилт үр дүнг тооцож байх.					хэрэгжих 6 нийт 9 хөтөлбөр арга хэмжээг Сангийн яамнаас баталсан загвар маягтын дагуу баталсан. Хэрэгжилт хагас жилийн байдлаар 68,9 хувьтай.	
4	Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан аймгийн ИТХТ-ийн 2020 оны 06 тогтоолын 2 дугаар хавсралтаар дагуу сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилт үр дүнг тайлагнах	Жилийн төлөвлөгөөг батлуулсан байх	Хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр зохион байгуулах	Тийм	Тийм	Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан сумын Засаг даргын 2020 оны 03 сарын 31-ны өдрийн А/45 тоот захирамжийн дагуу сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллаж байна. Албан байгууллагуудад хөрөнгийн тооллогыг 06-р сарын 15-наас 20-ны хооронд зохион байгуулан ажиллахаар төлөвлөсөн. 2022 оны жилийн эцсийн тооллогоор актлахаар шийдвэр гарсан 3ш хөрөнгийн 2 хөрөнгийг борлуулсан орлогыг төвлөрүүлэн ажиллалаа. Мөн ОНӨГазарт төрийн байгууллагууд жилийн эцсийн хөрөнгийн тайлангаа 100% амжилттай тайлагнаж өгсөн.	90
5	Улс болон орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь сар бүр жигд биелүүлэх.	Төлөвлөгөөг батлуулах	Сар бүр, нэр төрлөөр биелүүлэх	100	100	Улсын болон орон нутгийн төсвийн орлогыг цаг хугацаанд нь татварын болон татварын бус орлогын нэр төрлөөр бүрэн төвлөрүүлэн ажиллаж байна.Тухайлбал: Татварын орлого: *Улсын төсөв эхний хагаст 4550,0 төвлөрөхөөс 7362.8 төвлөрч 161,8 хувь *Аймгийн төсөв 12500,0 төвлөрөхөөс 18082,2 төвлөрч 144,6 хувь, *Сумын төсөв 64150,0 төвлөрөхөөс 66787,0 төвлөрч 104,1 хувь *Татварын бус орлого 9000,0	100

						төвлөрөхөөс 13989,8 төвлөрч 155,4 хувиар тус тус даван биелүүлжээ.	
6	Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалт, цахим албан хэрэг хөтлөлтийн тайланд улирал бүр дүгнэлт хийж, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст цахимаар ирүүлэх	тайланг хүргүүлэх	улирал бүр /тийм, үгүй/	-	тийм	Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалтын талаар албан хаагчид, мэргэжилтнүүдэд мэдээлэл сургалт явуулж Цахим албан хэрэг хөтлөлтийг ERP системээр өдөр тутамдаа ашиглаж байна. Тоон гарын үсгээр албан бичгээ илгээж хэвшсэн. 1-р улирлын тайланг хариуцсан мэргэжилтэнд явуулсан.	90
7	Цахим хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, аймаг орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх талаар тогтмол анхаарч үр дүнг сар бүр тооцон ажиллах	хандалт нэмэгдүүлэх	хандалтын тоо	25000	27000	Орон нутгаас зохион байгуулсан үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд ил тод хүргэх ажлыг тасралтгүй зохион байгуулж байна. Пэйж хуудасны нийтлэлийн хүртээмж 28 хоногтоо 21269, нийтлэлтэй харьцсан хандалтын байдал 38787 хагас жилийн байдлаар 106.345-193.935 хандалттай байна.	100
8	Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтын сайжруулж, цаг бүртгэл, үүрэг даалгаврын цахим системд шилжиж, нийт албан хаагчдын цахим ур чадвар, тоон боловсролыг дээшлүүлэх	сургалт зохион байгуулах	тийм, үгүй	тийм	тийм	Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтын сайжруулж, цаг бүртгэлийг өдөр тутамдаа тогтмол бүртгэн хэвшиж, албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх мэдээ мэдээлэл өгч ажиллаж байна. Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга 2 албан хаагчид тоон гарын үсэг авсан ашиглаж байна. 100% Цахим шилжилт-Цахим Дундговь цогц арга хэмжээний хүрээнд мэдээлэл технологийн сургалтыг аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн А.Мөнгөнийг урьж ил тод, ERP цахим сургалтыг зохион	100

						байгуулан 18 албан хаагч хамрагдсан. Мөн Байгууллагын админ, удирдлага, бичиг хэрэг хариуцсан ажилтнуудын дунд сургалтыг зохион байгуулж дадлага ажлыг хийснээр цахим сайтад мэдээлэл тавих, ил тод байдлын шалгуурын дагуу мэдээллээ оруулах үйл ажиллагаа жигдэрсэн.	
9	Гадаад, дотоод сүлжээний зохион байгуулалт, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх замаар байгууллагын ERP болон төрийн сангийн системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангаж албан хаагчдын ажиллах нөхцөл боломжоор хангах.	интернэтийн хурдыг нэмэгдүүлэх	шийдвэрлэс эн эсэх /тийм/ үгүй/	5мгв	10мгв	ИТХ, ЗДТГ, ЕБС, ЭМТ, Хүүхдийн цэцэрлэг, СТөв зэрэг байгууллагууд гадаад дотоод сүлжээний аюулгүй байдлаа бүрэн хангаж үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Интернэтийн дата 5 mbps хурдаар үйлчилгээг авдаг. Датаг нэмэгдүүлж dedicated 10 mbps болгохоор хүсэлтээ өгснөөр бүрэн шийдвэрлэлээ.	100
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах сумын орон тооны бус дэд салбар зөвлөл болон Залуучуудын хөгжлийн зөвлөлийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, төлөвлөгөө гарган батлуулж, тус зөвлөлүүдийн төлөвлөгөөг Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэх	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	90	91,0	Сумны Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийг 2023 оны 01 сарын 11 ний өдрийн А/04 тоот захирамжаар 23 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Төлөвлөгөөг Нийгмийн бодлогын хэлтэст цаг хугацаанд нь хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилийн байдлаар 60 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах сумын орон тооны бус дэд салбар зөвлөлийг томилж, ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Нийгмийн бодлогын хэлтэст явуулаагүй байна	50

11	0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	Үзлэгийг зохион байгуулах	Хамрагдалтын хувь	26	80	Тус сумын хүн амын бүртгэлд 0-17 насны 499 хүүхэд бүртгэлтэй бөгөөд эрт илрүүлэгт нийт 319 хүүхэд хамруулсан нь байнгын оршин суудаг хүүхдүүдээ бүрэн, хичээл сургууль амарсан цаг үед орон нутагт ирсэн хүүхдийг мөн үзсэн байна. Хамрагдалтын хувь 63,92%	70
12	Сумын нийт өрхийн 50-аас доошгүй хувийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг Соёл, урлагийн газарт 6,11 сарын 10-ны дотор тайлагнах	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	90	90	угийн бичиг хөтлөх ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжилтийн талаар СУГ-аас 2023.06.06ны өдөр цахим уулзалтаар мэдээлэл авсан. Сумын нийт өрхийн 70 хувь 2-5 үе хөтөлсөн.Төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилийн байдлаар 80 хувьтай байна.	80

13	Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, явцыг тайлагнаж хэвших	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	80	85	Сумын хэлний бодлогын салбар зөвлөлийг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Сумын Засаг даргын А/45 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж 04 сарын 27-ны өдөр хуралдан 2023 оны Хэлний бодлогын салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэлэлцэн баталж төлөвлөгөөний дагуу “Үндэсний бичгийн тээгч, түгээгч” уралдааныг иргэдийн дунд, “Цахим бичвэр”-ийн уралдааныг төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж шалгарсан 2 иргэн, 12 төрийн албан хаагчдыг Аймгийн Үндэсний бичиг үсгийг “Тээгч-түгээгч”, “Цахим бичвэр”, “Монгол бичгийн сорил” зэрэг уралдаанд амжилттай хамруулсан. Мөн Монгол бичгийн анги нийтийн улсын олимпиадад 7 дүгээр ангийн 12 хүүхэд хамрагдаж 6-р байр эзэлсэн. Байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө албан хаагчдаа монгол бичгийн сургалтад хамруулах, дадлагажуулах, сургах ажил арга хэмжээг төлөвлөн оруулснаар энэ 5-р сард анхан шатны сургалтыг 1 удаа зохион байгуулан 21 албан хаагч хамрагдсан байна. Монгол бичгийн түвшинг тогтоох ажил 3-р улиралд болно. Тайлангийн хэрэгжилт 75%	50
14	Эрх зүйн хөтчүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулан, судлан сурталчлах хууль эрх зүйн актын жагсаалтын дагуу улирал бүрийн сүүлийн	Сургалт зохион байгуулах	Эрх зүйн сургалт сурталчилгааг явуулах	Нийт иргэдийн 13%-д	Нийт иргэдийн 15%-д	Эрх зүйн хөтөч нарыг чадавхжуулах зорилгоор 1 удаагийн сургалт, цахим сургалт 1 удаа зохион байгуулан бүх эрх зүйн хөтөч болон мэргэжилтнүүд бүрэн хамрагдлаа. Эрх зүйн хөтөч	100

	сарын 25-ны дотор ХЭЗХ-т ирүүлэх					аяны цүнх 3-ыг бүтээж айл өрх, иргэдээр хууль эрх зүйн гарын авлага болон зөвлөгөө зөвлөмж зэргийг нийтдээ 113 иргэнд хүргэж ажилласан. Төрийн албан хаагчдын дунд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, Үндсэн хуулийн ач холбогдол, Татварын хуулийн талаар сургалтыг зохион байгуулж, Гэр бүлийн Дэвжээ тэмцээнийг явуулж давхардсан тоогоор 658 иргэнд үйлчилсэн. Эрх зүйн сургалт, сурталчилгаанд нийт иргэдийн 16.8% хамрагдсан байна.	
15	Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 6,11 сарын 10-ны дотор тайлагнах	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	90	91	“Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган 2 зорилт, хүрээнд 17 арга хэмжээг төлөвлөн эхний хагас жилийн хэрэгжилт 93,1 хувьтай хэрэгжсэн байна. Тайланг ТЗУХ-т хүргүүлсэн.	100
16	Төрийн албаны тухай хуулийн 55.3-ын дагуу байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, үр дүнг хагас бүтэн жилээр тооцож байх.	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	95	95,2	Байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөг батлуулсан. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт: ЗДТГ- 94 Соёлын төв 99 ЕБС 93 ХЦэцэрлэг 97 ЭМТөв 95	100

						Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт: ЗДТГ 95 ЕБС 90 ЭМТ 96 ХЦэцэрлэг 98 Соёлын төв 97 Дундаж 95,4	
		Хэрэгжилт 100-7, 97.6-1, 90-2, 80-1, 70-1, 50-2, 45-2,				82.35%	82.35

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

С.НАРАНТУНГАЛАГ

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ